

“Эрүүл мэндийн зан үйл өөрчлөх” агуулга НЭМС-ийн төгсөлтийн өмнөх сургалтын хөтөлбөрт тусгагдсан байдлыг үнэлэх нь

Саранчулуун О.¹, Оюун Ч.², Сугармаа М.¹

¹Нийгмийн эрүүл мэндийн сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль

² Монголын анагаахын эмэгтэй эрдэмтдийн холбоо

saranchuluun@mnums.edu.mn

Abstract

A summative content analysis: identifying content of “Health behavior change” in undergraduate curriculum of school of public health

Saranchuluun O.¹, Oyun Ch.², Sugarmaa M.¹

¹School of Public Health, Mongolian National University of Medical Sciences

²Mongolian women medical scientists’ association

saranchuluun@mnums.edu.mn

Justification

Researchers highlighted an importance of health professionals’ participation (1), (2), a role on behavior change in primary health care services (3) evidence based health policy and program (4)(5) байгааг and health promotion to reduce a prevalence of both communicable and non-communicable diseases in Mongolia. Mongolian National University of Medical Sciences trains public health researchers and health social workers in the last ten years. It has been developed a guideline of required compulsory professional competence in which, students of SPH should acquire knowledge, skills including behavior change strategy and implement interventions, behavior change assessment at individual, family, group and community levels.

Purpose

Aim of this research is to identify key words and content of "health Behavior" and "health Promotion" in undergraduate courses of School of public health (SPH) and compare with a content of compulsory professional competence requirements.

Methodology and Materials

We used a summative content analysis [6] to identify key words and content of “health behavior” and “health promotion” in 140 courses between 2009 and 2016 and compared with 17 required compulsory professional competence in blue print guideline [7].

Results

Planned academic hours of “health behavior and promotion” in courses of health social work was insufficient and they covered several theories with no content of implementation, application, evidence based practices and examples. For students of public health researchers, there are required compulsory 8 skills of health behavior, however skills and knowledge were slightly covered in courses of “food safety”, “health of kids and adolescent” and “occupational health”.

Conclusion

Undergraduate courses for health social workers and public health researchers were based solely on “individual health behavior theories”. The included content of the theory, application of organization and community behaviors was insufficient in the existing “health behavior” course.

Key words: health behavior, health social work, public health researcher, health promotion

Pp.29-34, Tables 2, References 10, Annexes 2

Үндэслэл

Судлаачид халдварт, халдварт бус өвчний тархалт буурах, эрсдэлт зан үйл өөрчлөхөд чиглэсэн эрүүл мэндийн дэмжих, нотолгоонд тулгуурласан эрүүл мэндийн бодлого, хөтөлбөр [1, 2], хүн амын эрсдэлт зан үйлийг өөрчлөх сайн туршлага хэрэгтэй, үүнийг эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний [3] түвшинд хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн оролцоо чухал [4, 5] байгааг онцолж байна.

Монгол улсын “Эрүүл мэндийн тухай хууль” [8]-д Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн тэргүүлэх чиглэлийг НЭМ-ийн тусламж үйлчилгээ гэж хуульчлан тусгасан бөгөөд АШУУИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуульд “Нийгмийн эрүүл мэнд судлалч”, “Эрүүл мэндийн нийгмийн ажилтан” мэргэжилтнүүдийг сүүлийн 10 жил бэлтгэж байна. Олон улсын стандарт, чиг хандлагад тулгуурлан 2016 онд АШУУИС-аас төгсөж буй мэргэжилтэн заавал эзэмших шаардлагатай мэдлэг, ур чадвар, гардан үйлдлийг цогц байдлаар зураглаж “мэргэжилтэний цогц чадамж” хэмээх баримт бичгийг боловсруулсан. Энэхүү баримт бичигт дээрх НЭМ-ийн төгсөж буй мэргэжилтнүүд нь хувь хүн, гэр бүл, бүлэг олон нийтийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх, судлах, интервенци хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлага эзэмшсэн байх шаардлагатай хэмээн тусгажээ [7]. Үүнтэй уялдуулан эдгээр заалтууд нь одоогоор зааж буй төгсөлтийн өмнөх сургалтын агуулгатай хэрхэн уялдаж байгааг харьцуулан үнэлж, улмаар сайжруулах шаардлагатай байна.

Зорилго, зорилт:

Энэхүү үнэлгээний зорилго НЭМС-ийн төгсөлтийн өмнөх сургалтын агуулгад “Эрүүл мэндийн зан үйл”, “Эрүүл мэндийг дэмжих” хичээлүүд хэрхэн тусгагдсаныг үнэлэх юм. Энэ хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэв.

Үүнд:

1. “Эрүүл мэндийн нийгмийн ажилтан”-ы төгсөлтийн өмнөх сургалтын агуулгад “эрүүл мэндийн зан үйл”, “эрүүл мэндийг дэмжих”-ийн үндсэн ойлголтууд, хувь хүн, нийт хүн амд чиглэсэн урьдчилан сэргийлэлтийн арга зам, интервенци, онолын хэрэглээ, зан үйл өөрчлөх зөвлөгөө, арга зүй тусгагдсан эсэхийг үнэлэх
2. “НЭМ судлалч”-ийн төгсөлтийн өмнөх сургалтын агуулгад “эрүүл мэндийн зан үйл”, “эрүүл мэндийг дэмжих”-ийн үндсэн суурь ойлголтууд, тодорхойлолтууд, хувь хүн, нийт хүн амд чиглэсэн урьдчилан сэргийлэлтийн арга зам, интервенци, онолын хэрэглээ, зан үйл өөрчлөх зөвлөгөө, арга зүй тусгагдсан эсэхийг үнэлэх

Судалгааны арга: Энэхүү судалгааг чанарын судалгааны нэг хэлбэр болох (summative content analysis) дүгнэх агуулгын дүн шинжилгээний аргыг [6] ашиглан хийв. Дүн шинжилгээ хийхдээ гол баримт бичиг болох АШУУИС-ийн “Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний цогц чадамжид тусгагдсан НЭМ судлалч, ЭМНА мэргэжилтэнүүдийн заавал эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт [7]-тай харьцуулав (Зураг 1). Зураг 1-т “Эрүүл мэндийн нийгмийн ажилтан” нь үйлчилгээний 3 үе шатанд зан үйл өөрчлөх, эрүүл мэндийн дэмжих чиглэлээр нийт 9 ур чадвар эзэмших ёстой гэж заасан байна.

Table 1. List of required professional competence in Health social work blue print

Phase of health social work service	Behavior change competence
Service planning	Assess risk behavior and use risk behavior questionnaire, tool
	Define level of risk behavior, develop guideline
Assessment	Develop content of behavior change counseling
Intervention	Consult behavior change
	Conduct study on behavior risk, health behavior
	Counsel using stage of change model
	Counsel on medical regimens
	Develop methods of risk behavior screening
	Reach out people with risky behavior of HIV/AIDS

Харин “Нийгмийн эрүүл мэндийн судлалч” мэргэжилтний зан үйл өөрчлөх, эрүүл мэндийн

дэмжихтэй холбоотой чиглэлээр заавал эзэмших 8 ур чадвар тусгагджээ (Хүснэгт 2).

Table 2. List of required professional competence in Public Health researcher’s blue print

Skills in Public health service	Behavior change competence
Skills related public health care service	Develop health diet recommendations
	Educate basic concepts of hygiene, food-borne disease, implement activities to minimize and prevent risk factor
	Organize activities to make healthy in kindergartens and schools
	Organize of health related activities among children with health problems
Determine priority problems of population and community	Determine factors affecting population health
Advocacy, collaboration and partnership	Identify activities and programs of governmental and non-governmental organizations to improve public health
	Develop public health intervention program
	Organize, assist and promote public health team

Судалгаанд ашигласан материал

Уг судалгаанд Нийгмийн эрүүл мэндийн сургуульд 2009-2016 оны хооронд батлагдсан төгсөлтийн өмнөх дамжаанд НЭМ судлалчийн ангид заагдах 84, ЭМНА-ны ангид заагддаг 56 буюу нийт 140 хичээлийн хөтөлбөрийг ашиглав.

Үүнд:

- НЭМ судлалчийн баклавын мэргэжлийн ангид ордог хичээлийн хөтөлбөр, стандартын хавтас (2015 он)
- ЭМНА-тны баклавын мэргэжлийн ангид ордог хичээлийн хөтөлбөр, стандартын хавтас (2015 он)
- ЭМНА, НЭМ-ийн 3р дамжаанд ордог “Эрүүл мэндийн зан үйл” хичээлийн хөтөлбөр (2016 он)
- Хичээлийн хөтөлбөрийн агуулгад “эрүүл мэндийг дэмжих”, “урьдчилан сэргийлэлт”, “эрүүл мэндийн зан үйл”, “эрүүл аж төрөх ёс” зэрэг түлхүүр үг ашиглан түүвэрлэж, холбогдох сэдвийн дагуух дэлгэрэнгүй тодорхойлолтыг уншиж тэмдэглэн, агуулга орсон хичээлийн лекц, семинарын гарчигийг төлөвлөсөн цагтай нь хүснэгтэнд тэмдэглэв.

Үр дүн:

Зорилт 1. НЭМС-ийн 2009-2016 онд батлагдсан ЭМНА-тны төгсөлтийн өмнөх сургалтанд заагддаг 56 хичээлийн хөтөлбөртэй танилцаж лекц семинарын сэдэвт “эрүүл мэндийн

урьдчилан сэргийлэлт”, “эрүүл мэндийн зан үйл”, “эрүүл мэндийг дэмжих” зэрэг үг, өгүүлбэр орсон 7 хичээл байв. ЭМНА-ны дамжаанд заагддаг ерөнхий, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлүүдээс “эрүүл мэндийн зан үйлийн суурь ойлголт, интервенци, зан үйлийн зөвлөгөө өгөх, онол ашиглах” агуулга орсон хичээлийн нэр, сэдэв, цагийн багтаамжийг харуулав (Хавсралт 1).

Хавсралт

Эрүүл мэндийн зан үйлийн агуулга орсон дээрх сэдэвт төлөвлөсөн цаг нь хангалтгүй, цөөхөн цагт олон төрлийн онолын ойлголт өгөхөөр тусгаж, харин аль нэг онолыг хэрэглэх, ашиглах, нотолгоонд тулгуурсан жишээн дээр ажиллах аргагүй, хэрэглээг төлөвлөөгүй байна. Тодруулбал, эрүүл мэндийн зан үйл, эрүүл мэндийг дэмжих хичээлүүдэд “эрүүл мэндийн зан үйлийн онол” сэдвийн агуулгын багтаамж их байгаа боловч төлөвлөсөн цаг нь бага (2 цаг лекц, 4 цаг семинар) байгаа нь оюутанд аль нэг онол практикийг ашиглахад суралцах боломж хангалтгүй байгааг харуулж байна.

Зорилт 2. НЭМС-ийн 2009-2016 онд батлагдсан НЭМ судлалчийн төгсөлтийн өмнөх сургалтад заагддаг 84 хичээлийн хөтөлбөрийг шүүж лекц, семинарын сэдэвт “эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт”, “эрүүл мэндийн зан үйл”, “эрүүл мэндийг дэмжих” тэй холбоотой үг өгүүлбэр орсон 11 хичээлийн нэр сэдвийг хавсралт 2-т үзүүлэв.

НЭМ судлалчийн сургалтанд нийт хичээлийн 9,24% буюу 84 хичээлээс 11 хичээлд “эрүүл мэндийн зан үйл”, “эрүүл мэндийн дэмжих” чиглэлийн агуулга бүхий сэдвүүд орсон байна. НЭМ судлалч мэргэжилтний цогц чадамжинд тусгасан заавал эзэмших зан үйлтэй холбоотой гардан үйлдлийн 10 ур чадвараас “Хүнсний эрүүл ахуй”, “Хүүхэд өсвөр үеийн эрүүл мэнд, эрүүл ахуй”, “хөдөлмөрийн эрүүл ахуй” зэрэг хичээлүүдэд цөөхөн цагаар төлөвлөгдсөн байна.

Хэлцэмж

ЭМНА-тны мэргэжлийн цогц чадамжид заавал эзэмших гардан үйлдлийн 10 нь “зан үйлийн өөрчлөлт”-ийн чиглэлээр буюу хувь хүн, гэр бүл бүлэг, олон нийтэд нөхцөл байдлын үнэлгээг хийх нэг чиглэлд нь эрсдэлт зан үйлийг илрүүлэх, эрсдлийн түвшин тодорхойлох гэж заажээ. Гэвч, энэхүү судалгаанд багтсан хичээлийн хөтөлбөрүүдэд эдгээр ур чадварыг эзэмшүүлэх лекц, семинарын агуулга тусгагдаагүй байна. Мөн ЭМНА-тны үйлчилгээ төлөвлөх, үйлчилгээ үзүүлэх шатанд тусгагдсан эрсдэлт зан үйлийг өөрчлөх зөвлөгөө өгөх, асуумж боловсруулах, шатчилсан зан үйлийн онолыг ашиглах ур чадваруудыг зөвхөн “ХДХВ/ДОХ, сүрьеэгийн чиглэлээр ажиллах нийгмийн ажил”, “Эрүүл мэндийн зан үйл” хичээлийн хөтөлбөрт цөөхөн цагаар тусгасан байна.

Цаашдаа ЭМНА-тны сургалтын агуулгад тухайн мэргэжлийн цогц чадамжинд тусгагдсан заавал эзэмших ур чадварын дагуу эрдсэлт зан үйлийг илрүүлэх, асуумж зохиох, стандарт асуумж хэрхэн хэрэглэх, мөн, ХДХВ/ДОХ-с гадна, архи тамхины хэрэглээ, эрсдэлт хүнсий хэрэглээ, сэтгэцийн эрүүл мэндийн, эмчилгээний дэглэмтэй холбоотой зан үйлийг өөрчлөх, хэвшүүлэх ур чадварыг онолд тулгуурлан эзэмшүүлэх, зөвлөгөө өгөх арга зүйн агуулга нэмж оруулах, эмнэлгийн нийгмийн ажил хичээлийн хүрээнд тодорхой өвчний үед баримтлах дэглэм сахиулах, зан үйлийн талаар оруулах шаардлагатай байна.

Харин НЭМ-ийн мэргэжлийн цогц чадамжинд тусгасан эрүүл мэндийн зан үйл, ЭМД, урьдчилан сэргийлэхтэй холбоотой 10 ур чадвараас ба сургалтанд тусгасан байдал нь “хүнсний эрүүл ахуй”, “хүүхэд өсвөр үеийн эрүүл мэнд, эрүүл ахуй”, “хөдөлмөрийн эрүүл ахуйн” гэсэн хичээлүүдэд л төлөвлөсөн байна. Мөн цогц чадамжийн НЭМ-ийн тусламж үйлчилгээний хэсэгт тусгагдсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлтийн зөвлөмж

боловсруулах, өдөрлөг зохион байгуулах, судалгаа хийх, үнэлгээ өгөх ур чадварууд нь хичээлийн төлөвлөгөөнд тусгагдахдаа урьдчилан сэргийлэлтийн уламжлалт алхамууд болох мэдлэг боловсрол дээшлүүлэх, танин мэдэхүйн чиглэлээр ажиллах, мэдээлэл өгөх гэсэн агуулгаар хязгаарлагдаж байна.

Энэхүү судалгаанд 2016 оноос хойш батлагдсан хөтөлбөрүүд багтаагүй бөгөөд, НЭМС-ын сургалтанд заагдаж буй бүх хичээлийг төлөөлөх боломжгүй юм. Эрсдэлт зан үйл өөрчлөх, дэмжих агуулгыг сайжруулахдаа зорилтот олон нийт, нийгэм, эдийн засаг, соёл уламжлалын хүчин зүйлсийг хамтад нь судлах, тэдний онцлогт тохируулах, нотолгоонд тулгуурласан арга зүйг хичээлийн хөтөлбөрт тусгах нь зүйтэй [9, 10].

Дүгнэлт:

1. ЭМНА-тны төгсөлтийн өмнөх сургалтын хөтөлбөрт “Эрүүл мэндийн зан үйл”, “Эрүүл мэндийн дэмжих” агуулга нь энэ чиглэлээр цогц чадамжинд тусгасан заавал эзэмших ур чадваруудыг эзэмшүүлэхэд хангалтгүй байна. Мэргэжлийн суурь, мэргэшүүлэх, тодорхой олон нийттэй ажиллах аргазүйн зарим хичээлүүдэд зан үйлийн өөрчлөлтийн талаарх агуулга нэмж оруулах шаардлагатай.
2. НЭМ судлалчийн сургалтанд нийтийн эрүүл мэндийн түгээмэл асуудлуудын гарал үүсэл, шалтгаан, хамаарлын холбоог ихэнхидээ багтаасан боловч, цогц чадамжинд тусгасаны дагуу заавал эзэмших урьдчилан сэргийлэх, нөлөөлөх, эрүүл зан үйл төлөвшүүлэх, олон нийттэй ажиллах чиглэлийн ур чадвар эзэмшүүлэх хичээлийн цаг, сэдэв хангалтгүй байна.

Ашигласан материал:

1. Noncommunicable Disease Prevention and Control in Mongolia: A Policy Analysis. Chimeddamba, Oyun, бас бус., бас бус. 2015 оны, BMC Public Health, хууд. 15:660 .
2. Trends in Adult Overweight and Obesity Prevalence in Mongolia, 2005-2013. Chimeddamba, Oyun, бас бус., бас бус. 2016 оны, Obesity , хууд. 24:10.
3. Implementation of clinical guidelines on diabetes and hypertension in urban Mongolia: a qualitative study of primary care providers' perspectives and experiences. Chimeddamba, Oyun, бас бус., бас бус. 2015 оны, Implementation Science, хууд. 10:112.

4. Outcomes of social work intervention in health care setting. Gail, K.Auslander. 2000 оны, Social work in health care, хууд. vol 31.
5. The Adoption of Roles by Primary Care Providers during Implementation of the New Chronic Disease Guidelines in Urban Mongolia: A Qualitative Study. Chimeddamba, Oyun, бас бус., бас бус. 2016 оны, International Journal of enviromental research and public health, хууд. 13:407.
6. Three Approaches to Qualitative Content Analysis. Hsiu Fang , Hsieh ба Sarah, E. Shannon. DOI: 10.1177/1049732305276687, с.л. : Qualitative Health Research, 2005 оны, Б. 15:1277.
7. АШУУИС. Мэргэжилтний цогц чадамж. Улаанбаатар: АШУУИС-ын хэвлэлийн газар, 2016.
8. УИХ. Монгол улсын хууль. Эрхзүйн мэдээллийн нэгдсэн систем. [Холбогдсон] 2011 оны 55. [Иштатсан: 2018 оны 3 14.] <http://www.legalinfo.mn/law/details/49?lawid=49>.
9. David W, Brook, бас бус., бас бус. Behavioral Medicine in Medical Education: report of a survey. [номын зохиолч.] Rosenberg Gary ба Weissman Andrew. Behavioral social work in health care settings. NYC : University of New York, 2000, хууд. 15.
10. Женний, Найдүү ба Жейн, Виллс. Эрүүл мэндийг дэмжих нь: практик ажлын үндэс. с.л. : Мөнхий үсэг ХХК, 2000. 0702021229.

Хавсралт 1. ЭМНА-ын ерөнхий, мэргэжлийн суурь ба мэргэшүүлэх хичээлүүдийн сэдэв, багтаамж

Хичээлийн нэр	Эрүүл мэндийн зан үйлийн суурь ойлголт, интервенци, зан үйлийн зөвлөгөө өгөх, онол ашиглах агуулга орсон хичээлүүд ба цагийн багтаамж холбоотой агуулга	Багтаамж
Ерөнхий суурь хичээл		
1	Нийгмийн сэтгэл судлал Олон нийтийн зан үйлд нөлөөлөх хүчин зүйлс	2 цаг лекц 4 цаг сем
2	Сэтгэлсудлал Зан үйл, нас зүйн сэтгэлзүй Зан үйлийг өөрчлөх арга тактик, зан үйлийн анагаах ухааны уялдаа холбоо, төрөл хэлбэр	2 цаг лекц 4 цаг сем
Мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээл		
3	ХДХВ/ДОХ Сүрьеэд чиглэсэн Н/ажил ХДХВ/ДОХ-с урьдчилан сэргийлэх нь: хувь хүний түвшиний интервенци Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх нь Өндөр эрсдэлт бүлгийн хүн амын түвшиний урьдчилан сэргийлэх нь	10 цаг лекц 12 цаг сем
4	ЭМАШТУ Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлс Эрүүл мэндийн боловсрол олгох, хүний зан үйлийг сэдэлжүүлэх өөрчлөх	2 цаг лекц, 4 цаг дад
5	Нийгмийн ажлын онол II Танин мэдэхүй , зан үйлийн онолууд	4 цаг лекц 4 цаг сем
6	Эрүүл мэндийн зан үйл Хүний зан үйл гэж юу вэ? Эрүүл мэндийн зан үйлийн талаарх онолын хандлага, түүхэн хөгжил Хувь хүний зан үйлийн тухай үндсэн онолууд: эрүүл мэндийн итгэл үнэмшлийн загвар, шалтгаант үйлдлийн онол, төлөвлөсөн зан үйлийн онол Зан үйлийг өөрчлөх байгууллага, олон нийтийн зан үйлийн өөрчлөлтийн стратеги Харилцаан холбооны технологи, сургалт сурталчилгаа ба ЭМ-ийн дэмжих хөтөлбөрүүд Зан үйлийн экологи ба эрүүл мэндийн мэдэгдэхүүн, хэвлэл мэдээлэл	16 цаг лекц 32 цаг сем
7	Эрүүл мэндийг дэмжих ЭМД үйл ажиллагаа ЭМД орчин ОН-ын оролцоог нэмэгдүүлэх Хувь хүний эрүүл мэндээ хамгаалах чадвардыг хөгжүүлэх ЭМ-ийн боловсрол ба олон нийтийн мэдээллийн хэрэгсэл Эрүүл мэндийг тодорхой орчинд дэмжих аргууд	24 цаг лекц, 16 цаг дад

Хавсралт 2. НЭМ судлалчийн ерөнхий, мэргэжлийн суурь ба мэргэшүүлэх хичээлүүдийн сэдэв, багтаамж

	Хичээлийн нэр	Эрүүл мэндийн зан үйлийн суурь ойлголт, интервенци, зан үйлийн зөвлөгөө өгөх, онол ашиглах агуулга орсон хичээлүүд ба цагийн багтаамж холбоотой агуулга	Багтаамж
Ерөнхий суурь хичээл			
1	Сэтгэл судлалын үндэс	<ul style="list-style-type: none"> Зан үйл, нас зүйн сэтгэлзүй Зан үйл өөрчлөх арга тактик, зан үйлийн анагаах ухааны уялдаа холбоо, төрөл хэлбэр 	2 цаг лекц 2 цаг сем
Мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээл			
2	НЭМ -ийн үндэс	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа Эрүүл мэндийн боловсрол НЭМ-ийн сургалт, сурталчилгаа 	4цаг лекц 8цаг дад
3	УСАУ	Эрүүл мэндийг дэмжих: зорилтот бүлгийн эрсдэлт зан үйлийг судлах, өөрчлөх алхам төлөвлөх	2 цаг лекц 4цаг сем
4	Хүнсний эрүүл ахуй	Хоол хүнсээс хамааралтай халдварт бус өвчнүүдийн үндсэн ойлголт, урьдчилан сэргийлэлт	6цаг лекц 12цаг дад
5	Нийгмийн эрүүл мэндийн практик	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг төлөвлөх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулах, зорилтот болон нийтлэг хөтөлбөр, олон буюу нэг түвшний хөтөлбөр боловсруулах ЭМД боловсрол, НЭМ-ийн сургалт, сурталчилгаа, зан үйлийг өөрчлөх онол 	6цаг лекц 12цаг дад
6	Хүүхэд өсвөр үеийн ЭМ, эрүүл ахуй	Хүүхдийн байгууллагад зохиогдох эрүүлжүүлэх арга хэмжээ	4 цаг лекц 8 цаг дад
7	Хөдөлмөрийн эрүүл ахуй	<ul style="list-style-type: none"> Ажилчдад эрүүл мэндийн боловсрол олгох, зохион байгуулалт Эрүүл ажлын байр хөтөлбөр 	2 цаг лекц 4 цаг дад
8	Халдварт өвчин судлал	Бүх төрлийн халдварт өвчний эмнэл зүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт	4цаг лекц 48 цаг дад
9	Эрүүл мэндийг дэмжих-I	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийг дэмжих (ЭМД) үйл ажиллагааны хөгжил ЭМД загвар ба аргууд (эмнэлгийн арга, зан үйлийн өөрчлөлтийн арга, боловсролын арга, чадавхижуулалт, нийгмийн өөрчлөлтийн арга) ЭМД боловсрол, зан үйлийг өөрчлөх онол хувь хүний онол ЭМ-ийг дэмжихэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах нь 	12цаг лекц, 24цаг дад
10	Эрүүл мэндийг дэмжих-II	<ul style="list-style-type: none"> ЭМД дэмжихэд хийгдэх үнэлгээ ЭМД ОН-тэй ажиллах, тулгамдсан асуудлыг тодорхойлох, ОН-ийг хөгжүүлэх Эрүүл бус зан үйлийг өөрчлөх, хүмүүст өөрчөгдөхөд нь туслах ЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээ ба эмнэлгүүдэд эрүүл мэндийг дэмжих Эрүүл ажлыг байрыг хөгжүүлэх, ажлын байранд ба сургуулиудад ЭМД хийх нь 	16 цаг лекц, 32 цаг дад
11	Эрүүл мэндийн зан үйл	<ul style="list-style-type: none"> Хүний зан үйл гэж юу вэ? Эрүүл мэндийн зан үйлийн талаарх онолын хандлага, түүхэн хөгжил Хувь хүний зан үйлийн тухай үндсэн онолууд: эрүүл мэндийн итгэл үнэмшлийн загвар, шалтгаант үйлдлийн онол, төлөвлөсөн зан үйлийн онол Зан үйлийг өөрчлөх байгууллагын олон нийтийн түвшний загварууд Харилцаан холбооны технологи, сургалт сурталчилгаа ба ЭМ-ийн дэмжих хөтөлбөрүүд Зан үйлийн экологи ба эрүүл мэндийн мэдэгдэхүүн, хэвлэл мэдээлэл 	16 цаг лекц 32 цаг сем

Танилцаж, нийтлэх санал өгсөн:

Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор Б.Бурмаажав